

Бизнесийн төлөвийн түүвэр судалгаа (2025 оны III улирал)

Хураангуй:

“Бизнесийн төлөвийн түүвэр судалгаа”-ны мэдээллийг 2025 оны 10 дугаар сард цуглуулж, 405 аж ахуйн нэгжийн мэдээлэлд үндэслэн судалгааны үр дүнг нэгтгэлээ.

- Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн дийлэнх нь хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК) хэлбэртэй, хүнсний болон хүнсний бус боловсруулах үйлдвэрлэл, барилга, дотоод худалдааны салбарт үйл ажиллагаа эрхэлдэг, 10-аас дээш жилийн туршлагатай, 200 хүртэл ажилтантай, жилийн 2.5 тэрбум төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой байна.
- Түүвэр судалгаанд хамрагдсан иргэдийн хариултаас хүлээгдэж буй инфляцыг тооцвол:

Инфляцын хүлээлт	2025 оны IV улиралд	2026 оны III улиралд
Дундаж хүлээлт	8.7%	9.5%
Медиан хүлээлт	9.6%	10.2%

Ирэх 3 сар болон ирэх 12 сарын хугацаанд холбоо шуудангийн үйлчилгээ, боловсролын үйлчилгээ, гэр ахуй, бусад бараа эрхэлдэг ААН-үүдийн хувьд бараа, үйлчилгээний үнэ 10 нэгжээс дээш хувиар өсөх хүлээлт давамгайлж байна. Харин эм, эмнэлгийн үйлчилгээ, орон сууц, ус, цахилгаан болон хувцас, бөс бараа эрхэлдэг ААН-үүдийн хувьд бараа, үйлчилгээний үнэ 10 нэгжээс доош хувиар буурах хүлээлт давамгайлж байна.


2024 оны 6 сараас хойш гурван улирал дараалан нэмэгдээд байсан инфляцын хүлээлтийн утга сүүлийн хоёр улиралд дараалан бага зэрэг буурсан төлөвтэй байна.

- **Эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт:** Аж үйлдвэрийн салбарын үзүүлэлт бага зэрэг өссөн (+7.9) бол дотоод худалдаа (-21.1), хэрэглэгчдийн (-16.0), барилга (-12.6), үйлчилгээний (-0.9) салбарын үзүүлэлт тус тус буурснаар эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт өмнөх улирлаас 2.0 нэгжээр буурч, тайлант улиралд **87.3**-тай буюу ААН-үүдийн эрэлт, үйлдвэрлэлийн идэвхжил сул байгааг илтгэж байна.
- **Ажил эрхлэлтийн хүлээлтийн үзүүлэлт:** Үйлчилгээ (+11.4), аж үйлдвэр (+3.9) болон дотоод худалдаа (+1.5)-ны салбаруудад ажил эрхлэлтийн хүлээлт бага зэрэг өссөн бол барилгын (-13.8) салбарын ажил эрхлэлтийн хүлээлт буурлаа. Улмаар тус үзүүлэлт өмнөх улирлаас 6.0 нэгжээр өсөж, тайлант улиралд **99.8**-тай буюу өөрчлөлтгүй түвшинд гарлаа.
- **Эдийн засгийн тодорхой бус байдлын үзүүлэлт:** Хэрэглэгч (-65.8), дотоод худалдаа (-32.5), аж үйлдвэр (-26.3), үйлчилгээ (-22.5) болон барилгын (-2.8) салбарын тодорхой бус байдлын үзүүлэлт тус бүр буурснаар эдийн засгийн тодорхой бус байдлын ерөнхий үзүүлэлт өмнөх улирлаас 32.2 нэгжээр буурлаа. Хэдий ингэж буурсан ч эдийн засгийн тодорхой бус байдлын үзүүлэлт тэлэлтийн мужид, **111.2** утгатай буюу тодорхой бус байдал өндөр хэвээр байна.


I. Аж ахуйн нэгжүүдийн инфляцын хүлээлт

Судалгаанд хамрагдсан ААН-үүдээс инфляц хэрхэн өөрчлөгдөх талаар асууж, чиглэлийн индексийг тооцоход ирэх 3 сар болон ирэх 12 сарын чиглэлийн индексийн утгууд өнгөрсөн улирлын түвшнээс бага зэргийн өсөж, индекс тус бүрийн утга “Үнийн өсөлт өснө” мужид хэвээр гарлаа (Зураг 1.1).

Зураг 1.1: Инфляцын хүлээлтийн индекс, ирэх 3 болон 12 сарын хугацаанд




Зураг 1.2: Инфляцын хүлээлт, ирэх 3 болон 12 сарын хугацаанд




ААН-үүдийн ирэх хугацааны инфляцын хүлээлтийн тоон хариултад үндэслэн дундаж утгыг тооцоход 2025 оны IV улирлын хүлээлт өмнөх улирлаас 0.3 нэгж хувиар буурч **8.7%**, 2026 оны III улирлын хүлээлт мөн өмнөх улирлаас 0.3 нэгж хувиар буурч **9.5%**-тай тус тус гарлаа (Зураг 1.2). Харин инфляцын хүлээлтийн тоон хариултаас медиан¹ утгыг тооцоход 2025 оны IV улирлын хүлээлт өмнөх улирлаас 0.2 нэгж хувиар буурч **9.6%**, 2026 оны III улирлын хүлээлт өмнөх улирлаас 0.4 нэгж хувиар буурч **10.2%**-тай гарлаа (Зураг 1.3-Зураг 1.4). Мөн 2024 оны 6 сараас хойш гурван улирал дараалан нэмэгдээд байсан инфляцын хүлээлтийн утга сүүлийн хоёр улиралд дараалан бага зэрэг буурсан төлөвтэй байна (Зураг 1.3-Зураг 1.4).

Зураг 1.3: Тоон хариултаас тооцсон инфляцын хүлээлтийн медиан & дундаж утга, ирэх 3 сар



Зураг 1.4: Тоон хариултаас тооцсон инфляцын хүлээлтийн медиан & дундаж утга, ирэх 12 сар



¹ Тоон асуулгын хариултаас Nicholas J. Cox (2009)-ийн боловсруулсан “Хагас тархалтын функц” болон “Симметрик шугаман интерполяци медиан” аргачлалыг ашиглан тоон хүлээлтийн тархалт болон медиан утгыг тооцсон болно.

ААН-үүдийн борлуулалтын бүтэц дэх бараа, үйлчилгээний төрөлд тулгуурлан ХҮИ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээний бүлгийн дагуу бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг, худалдаалдаг болон үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгжүүдээр нь ангилж, инфляцын хүлээлтийг бүлэглэн харьцууллаа. Үүний үр дүнд, ирэх 3 сард дийлэнх аж ахуйн нэгжүүд (44%) үнийн өсөлт 10.0 хувиас дээш байх хүлээлт давамгайлж байна. Тухайлбал, боловсролын үйлчилгээ, гэр ахуйн бараа, зочид буудал болон хоолны газар эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн үнийн өсөлт 10.0 хувиас дээш байх хүлээлт давамгайлж байна (Зураг 1.5). Мөн ирэх 12 сард дийлэнх аж ахуйн нэгжүүд (56%) үнийн өсөлт 10.0 хувиас дээш байх хүлээлттэй давамгайлж байна. Тухайлбал, холбоо шуудангийн үйлчилгээ, боловсролын үйлчилгээ, зочид буудлын үйлчилгээ, гэр ахуй бусад бараа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн үнийн өсөлт 10.0 хувиас дээш байх хүлээлт давамгайлж байна (Зураг 1.6).


Зураг 1.5: ААН-ийн ирэх 3 сарын инфляцын хүлээлт, /бүтээгдэхүүн, үйлчилгээний бүлгээр/



Зураг 1.6: ААН-ийн ирэх 12 сарын инфляцын хүлээлт, /бүтээгдэхүүн, үйлчилгээний бүлгээр/



Тоон хариултын интервал тус бүрийн дундаж утгаар жигнэн инфляцын хүлээлтийн утгыг тооцвол инфляцын ирэх 3 сарын хүлээлт өмнөх улирлаас 0.3 нэгж хувиар буурч **8.7%**, ирэх 12 сарын хүлээлт 0.3 нэгж хувиар буурч **9.5%**-тай байх хүлээлттэй байна (Зураг 1.7). **Зураг 1.7: ААН-ийн ирэх хугацааны инфляцын хүлээлтийн тархалт, тоон хариулт**




II. Бизнесийн үйл ажиллагааны төлөв


Эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт ESI²

Монгол Улсын эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт өмнөх улирлаас 2.0 нэгжээр буурч, 2025 оны III улиралд **87.3** утгатай гарлаа. Энэ нь өнгөрсөн улирлын утгатай ойролцоо бөгөөд агшилтын мужид хэвээр байна (Зураг 2.1). Ерөнхий салбаруудын индексийг харвал бүгд 100-аас доош (аж үйлдвэр 96.1, барилга 76.4, дотоод худалдаа 68.6, үйлчилгээ 86.2, хэрэглэгч 78.9) буюу агшилтын мужид байна. Энэхүү үзүүлэлтийг өмнөх улирлын үр дүнтэй харьцуулахад аж үйлдвэр (+7.9) өссөн бол дотоод худалдаа (-21.1), хэрэглэгч (-16.0), барилга (-12.6) болон үйлчилгээ (-0.9)-ний салбаруудад тус тус бууралттай гарлаа (Зураг 2.2).

Зураг 2.1: Эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт



Зураг 2.2: Эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт, салбараар



Тэмдэглэл: Энэхүү үзүүлэлт нь эдийн засагт оролцогч талуудын (хэрэглэгч) өнгөрсөн 3 сарын ийн захиалга, борлуулалт (санхүүгийн байдал, эдийн засгийн нөхцөл байдал), барааны нөөц, ирэх 3 сарын үйлдвэрлэл болон ажил эрхлэлт (санхүүгийн байдал, хэрэглээ, эдийн засгийн нөхцөл байдал) зэрэг үзүүлэлтүүдийн талаарх хүлээлтийн дунджаар тодорхойлогдох бөгөөд Евро комиссын “European Business Cycle Indicators” тайлангийн аргачлалд тулгуурлан тооцлоо. Үзүүлэлт 100-с дээш гарах нь эдийн засгийн нөхцөл байдал сайжрах, 100-с бага бол эдийн засгийн нөхцөл байдал муудах төлөвийг илэрхийлнэ.


Тэмдэглэл: Төвөөс алслагдсан утга нь тухайн үзүүлэлт сайжирч байгааг илтгэх бөгөөд тус нийлмэл утга нь тухайн үзүүлэлтийг тооцохдоо Евро комиссын “European Business Cycle Indicators” тайлангийн аргачлалыг жишиг болгон аж үйлдвэр 40%, үйлчилгээ 30%, хэрэглэгч 20%, барилга 5%, дотоод худалдаа 5%-иар жигнэн тооцсон болно.

² Economic Sentiment Index


Ажил эрхлэлтийн хүлээлтийн үзүүлэлт (EEI)³

Тайлант улиралд **99.8** утгатай буюу 100-тай ойролцоо гарсан нь ажиллагсдын тоо ирэх улиралд өөрчлөлтгүй байх хүлээлттэй байна. Үзүүлэлт өмнөх улирлаас 6.0 нэгжээр өссөн нь ажил эрхлэлт бага зэрэг өсөх дохио болохыг илтгэж байна (Зураг 2.3). Үйлчилгээ (103.3) болон аж үйлдвэр (100.0)-ийн салбаруудад ажил эрхлэлтийн хүлээлтийн үзүүлэлт өмнөх улирлаас бага зэргийн өсөж тэлэлтийн мужид шилжсэн бол барилга (84.7) болон дотоод худалдаа (95.7)-ны салбарууд агшилтын мужид хэвээр үлдлээ. Тус үзүүлэлтийг өмнөх улирлын утгатай харьцуулахад үйлчилгээ (+11.4), аж үйлдвэр (+3.9), дотоод худалдаа (+1.5)-ны салбаруудад өссөн бол барилга (-13.8) тайлант улиралд бууралттай гарлаа (Зураг 2.4).

Зураг 2.3. Ажил эрхлэлтийн хүлээлтийн үзүүлэлт



Зураг 2.4. Ажил эрхлэлтийн хүлээлтийн үзүүлэлт, салбараар



Эдийн засгийн тодорхой бус байдал (EUI)⁴

Монгол Улсын эдийн засгийн тодорхой бус байдлын талаар аж ахуйн нэгж, иргэдээс асууж, хүлээлтийн утгыг тооцоход 2025 оны III улиралд өмнөх улирлаас 32.2 нэгжээр буурсан ч, **111.2** буюу эдийн засгийн тодорхой бус байдлын үзүүлэлт өмнөх улирлаас нэмэгдсэн байна. Дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдлын үзүүлэлт өмнөх улирлаас нэмэгдсэн байна. Тухайлбал, ОУВС-аас эрхлэн гаргадаг “Дэлхийн эдийн засгийн төлөв” тайланд гадаад худалдааны геополитикийн нөхцөл байдал богино хугацаанд тогтворжиж, тохиролцоонд хүрсэн боловч урт хугацааны бодлогын тодорхойгүй байдал өндөр хэвээр байна. Түүнчлэн, дийлэнх улс оронд инфляц буурах хандлагатай байгаа бол улс орнууд төсвийн тэлэлтийн бодлого баримталж байгаа нь өрийн түвшин өндөр, зээлийн өртөг нэмэгдэж буй нөхцөлд эдийн засагт сорилт учруулж болзошгүйг тусгажээ.


Голлох салбаруудын хувьд авч үзвэл, эдийн засгийн тодорхой бус байдлын үзүүлэлт барилгын салбарт хамгийн өндөр (барилга 122.2, үйлчилгээ 117.2, аж үйлдвэр 112.6, дотоод худалдаа 111.6, хэрэглэгч 96.8) байгаа бол харин хэрэглэгчдэд харьцангуй бага утгатай гарлаа. Тус үзүүлэлтүүдийг өмнөх улирлын утгатай харьцуулахад бүх салбарт тодорхой бус

³ Employment Expectation Index


⁴ Economic Uncertainty Index

байдал буурсан (хэрэглэгч -65.8, дотоод худалдаа -32.5, аж үйлдвэр -26.3, үйлчилгээ -22.5 барилга -2.8) дүр зурагтай байна (Зураг 2.6).

Зураг 2.5. Эдийн засгийн тодорхой бус байдал



Зураг 2.6. Эдийн засгийн тодорхой бус байдал, салбараар



Бусад үзүүлэлтүүд


Ирэх улирлын эрэлтийн хүлээлт өмнөх улирлаас 14.3 нэгжээр буурч, **85.2** утгатай буюу агшилтын мужид хэвээр гарлаа. Салбарын түвшинд авч үзвэл барилга, үйлчилгээ, аж үйлдвэр, дотоод худалдааны хүлээлт буурсан байна (Зураг 2.7). Ирэх улирлын экспортын хүлээлт өмнөх улирлаас 3.2 нэгжээр өсөж **95.7** утгатай буюу агшилтын мужид хэвээр хадгалагдлаа. Салбарын түвшинд авч үзвэл дотоод худалдаа, үйлчилгээ, аж үйлдвэрийн салбарын хүлээлт өссөн бол барилгын салбарын хүлээлт бага зэрэг буурсан байна (Зураг 2.8). Тодруулбал, эрэлтийн голлох салбарын хүлээлтүүд 83.3–91.3, экспортын голлох салбарын хүлээлтүүд 91.7–100.0 нэгжийн хооронд байна.

Ирэх улирлын зээлийн хүүний хүлээлт тайлант улиралд 9.6 нэгжээр буурч, **126.3** утгатай буюу зээлийн хүү өсөх мужид хэвээр хадгалагдлаа. Салбарын түвшинд авч үзвэл аж үйлдвэр, хэрэглэгчид, дотоод худалдаа, үйлчилгээний салбарын хүлээлт буурсан бол барилгын салбарын хүлээлт бага зэрэг өссөн байна (Зураг 2.9). Ирэх улирлын ханшийн хүлээлт өмнөх улирлаас 5.3 нэгжээр өсөж, **160.3** утгатай төгрөг сулрах мужид хэвээр хадгалагдлаа. Салбарын түвшинд авч үзвэл дотоод худалдаа, барилга, аж үйлдвэр, салбарт ханш сулрах хүлээлт нэмэгдэж, үйлчилгээ салбарт ханш өсөх хүлээлт бага зэрэг буурсан байна (Зураг 2.10). Тодруулбал, зээлийн хүүний голлох салбарын хүлээлтийн үзүүлэлтүүд 94.9–142.0, ханшийн голлох салбарын хүлээлтийн үзүүлэлтүүд 150.7–168.1 нэгжийн хооронд байна.

Ирэх улирлын нэгж бүтээгдэхүүний зардлын хүлээлт өмнөх улирлаас 6.5 нэгжээр өсөж, **164.2** утгатай тэлэлтийн мужид хэвээр гарлаа. Салбарын түвшинд авч үзвэл аж үйлдвэр, барилгын салбарын хүлээлт буурсан бол дотоод худалдаа, үйлчилгээний салбарын хүлээлт өссөн байна (Зураг 2.11). Ирэх улирлын ажиллах хүчний зардлын хүлээлт өмнөх улирлаас 3.8 нэгжээр өсөж, **145.8** утгатай тэлэлтийн мужид хэвээр гарлаа. Салбарын түвшинд авч үзвэл аж үйлдвэр, дотоод худалдаа, үйлчилгээний салбарын хүлээлт өссөн бол барилгын

салбарын хүлээлт буурсан байна (Зураг 2.12). Тодруулбал, нэгж бүтээгдэхүүний зардлын голлох салбарын хүлээлтийн үзүүлэлтүүд 100.0–171.0, ажиллах хүчний голлох салбарын хүлээлтийн үзүүлэлтүүд 156.5–86.9 нэгжийн хооронд байна.

Зураг 2.7. Эрэлтийн хүлээлтийн үзүүлэлтийн үзүүлэлт




Зураг 2.8. Экспортын хүлээлтийн үзүүлэлт




Зураг 2.9. Зээлийн хүүний хүлээлтийн үзүүлэлт




Зураг 2.10. Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн хүлээлтийн үзүүлэлт



Зураг 2.11. Нэгж бүтээгдэхүүний зардлын хүлээлтийн үзүүлэлт



Зураг 2.12. Ажиллах хүчний зардлын хүлээлтийн үзүүлэлт



III. Хавсралт 1. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн ерөнхий мэдээлэл

Түүвэр судалгааг 2025 оны 10 дугаар сард явуулж, нийт **405** аж ахуйн нэгж (ААН) хамрагдсан бөгөөд өмчлөлийн хэлбэрээр авч үзвэл 392 (97%) нь хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК), 9 (2%) нь хувьцаат компани (ХК), үлдсэн 4 (1%) нь бусад төрлийн өмчлөлийн хэлбэртэй ААН-үүд байна /Хүснэгт 1.1/.

Хувийн хэвшлийн ААН-үүд судалгаанд голлон хамрагдсан бөгөөд тэдгээрийн 22% нь 20-с дээш, 13% нь 15-20 жилийн, 26% нь 10-15 жилийн, 28% нь 5-10 жилийн бол 11% нь 5-с доош жилийн турш үйл ажиллагаа эрхэлсэн ААН-үүд байна /Хүснэгт 1.2/.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл бөөний болон жижиглэн худалдааны 69 (17%), хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн 68 (17%), барилгын 72 (18%), хүнсний бус боловсруулах үйлдвэрлэлийн 58 (14%), уул уурхайн 10 (2%), үйлчилгээний 128 (32%) ААН-үүд судалгаанд хамрагдлаа /Хүснэгт 1.3/.

Жилийн борлуулалтын орлогоор авч үзвэл 2.5 тэрбум төгрөгөөс дээш орлоготой 152 (38%), 1.0-2.5 тэрбум төгрөгийн орлоготой 63 (16%), 300 саяас 1.0 тэрбум төгрөгийн орлоготой 91 (22%), 50.0-300.0 сая төгрөгийн орлоготой 62 (15%), 50 сая төгрөгөөс доош орлоготой 37 (9%) аж ахуйн нэгжүүд судалгаанд оролцлоо /Хүснэгт 1.4/.

Хүснэгт 1.1: Аж ахуйн нэгжийн тоо /өмчлөлөөр/

Өмчлөлийн хэлбэрийн ангилал	тоо	хувь
ХХК	392	97%
Хувьцаат компани	9	2%
Бусад	4	1%
НИЙТ ДҮН	405	100%

Хүснэгт 1.2: Аж ахуйн нэгжийн тоо /туришлага, жилээр/

Хугацааны ангилал	тоо	хувь
5 хүртэл	44	11%
5-10 хүртэл	114	28%
10-15 хүртэл	106	26%
15-20 хүртэл	53	13%
20-с дээш	88	22%
НИЙТ ДҮН	405	100%

Хүснэгт 1.3: Аж ахуйн нэгжийн тоо /салбараар/

Салбарын ангилал	тоо	хувь
Уул уурхай, олборлолт	10	2%
Боловсруулах үйлдвэрлэл /хүнсний/	68	17%
Боловсруулах үйлдвэрлэл /хүнсний бус/	58	14%
Барилга	72	18%
Бөөний болон жижиглэнгийн худалдаа	69	17%
Үйлчилгээний	70	17%
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	5	1%
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	11	3%
Зочид буудал, байр, сууц болон хоол	9	2%
Мэдээлэл, холбоо	7	2%
Санхүүгийн болон даатгалын ү.а	9	2%
Боловсрол	6	1%
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамж	11	3%
НИЙТ ДҮН	405	100%

Хүснэгт 1.4: Аж ахуйн нэгжийн тоо /орлогоор/

Орлогын ангилал	тоо	хувь
50 сая төгрөг хүртэл	37	9%
50-300 сая төгрөг хүртэл	62	15%
300 сая-1.0 тэрбум төгрөг хүртэл	91	22%
1.0-2.5 тэрбум төгрөг хүртэл	63	16%
2.5 тэрбум төгрөгөөс дээш	152	38%
НИЙТ ДҮН	405	100%

Жилийн борлуулалтын орлого болон ажилчдын тооны бүлгээр ангилбал 10 хүртэл ажилтантай эсвэл 2.5 тэрбум төгрөг хүртэл орлоготой бичил ангилалд хамаарах 161 (40%), 10-аас 200 хүртэл ажилтантай эсвэл 2.5 тэрбум төгрөг хүртэл орлоготой жижиг, дунд ангилалд хамаарах 91 (22%), 200-с дээш ажилтантай эсвэл 2.5 тэрбум төгрөгөөс дээш орлоготой том ангилалд хамаарах 153 (38%) аж ахуйн нэгж судалгаанд хамрагдлаа /Хүснэгт 1.5/.

Хүснэгт 1.5: Аж ахуйн нэгжийн тоо /орлого, ажилтны тооны бүлгээр/

Борлуулалтын орлого	Ажилчдын тоо /бүлгээр/				Бүгд
	< 10	11–49	50–199	200= <	
50 сая төгрөг хүртэл	33	4	0	0	9%
50-300 сая төгрөг хүртэл	53	9	0	0	15%
300 сая-1.0 тэрбум төгрөг хүртэл	53	37	1	0	22%
1.0-2.5 тэрбум төгрөг хүртэл	22	37	3	1	16%
2.5 тэрбум төгрөгөөс дээш	11	64	56	21	38%
НИЙТ ДҮН	172	151	60	22	100%

IV. Хавсралт 2. Аргачлалын тайлбар

Эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт (ESI)

Энэхүү үзүүлэлтийг тооцохдоо Евро комиссын “European Business Cycle Indicators” тайланд тусгагдсан аргачлалын дагуу тооцлоо. Эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт нь аж ахуйн нэгжийн болон хэрэглэгчдийн түүвэр судалгаанд хамрагдсан таван үндсэн салбарын аж ахуйн нэгж, хэрэглэгчдээс сонгогдсон асуултуудад өгсөн хариултуудын жигнэсэн дундаж үзүүлэлт юм. Аж үйлдвэр (жин 40%), үйлчилгээ (30%), хэрэглэгчид (20%), жижиглэн худалдаа буюу дотоод худалдаа (5%), барилгын салбарууд (5%) хамаарна. Аж үйлдвэрийн салбараас тухайн улирлын **шинэ захиалга, бэлэн бүтээгдэхүүний нөөц**, ирэх улирлын **үйлдвэрлэл**, барилгын салбараас тухайн улирлын **шинэ захиалга**, ирэх улирлын **ажил эрхлэлт**, дотоод худалдааны салбараас тухайн улирлын **борлуулалтын орлого, худалдан борлуулах барааны нөөц**, ирэх улирлын **борлуулалтын орлого**, үйлчилгээний салбараас тухайн улирлын **бизнесийн үйл ажиллагааны нөхцөл байдал, шинэ захиалга**, ирэх улирлын **борлуулалтын орлого**, хэрэглэгчдээс тухайн улирлын **санхүүгийн байдал**, ирэх улирлын **санхүүгийн байдал, хэрэглээ** болон **эдийн засгийн нөхцөл байдал** зэрэг үзүүлэлтүүдийг асууж, асуулт тус бүрийн эерэг сөрөг хариултуудын нийт хариултад эзлэх хувийн зөрүүгээр тодорхойлсон болно.

Ажил эрхлэлтийн хүлээлтийн үзүүлэлт (EEI)

Энэхүү үзүүлэлтийг тооцохдоо Евро комиссын “European Business Cycle Indicators” тайланд тусгагдсан аргачлалын дагуу тооцлоо. Ажлын эрхлэлтийн хүлээлтийн индекс нь судалгаанд хамрагдсан дөрвөн үндсэн салбарын аж ахуйн нэгжүүдийн хүлээлтийн жигнэсэн дунджаар тооцогдоно. Аж үйлдвэр (жин 23%), барилга (8%), жижиглэн худалдаа буюу дотоод худалдаа (18%), үйлчилгээний салбарууд (51%) хамаарна. ААН-үүдээс **ирэх улирлын ажил эрхлэлт** хүлээлтийн өөрчлөлтийг судалж, “Өснө”, “Буурна”, “Мэдэхгүй”, “Хэвэндээ” гэсэн дөрвөн хариултын эерэг/сөрөг балансаар тодорхойлсон болно.

Эдийн засгийн тодорхой бус байдлын үзүүлэлт (EUI)

Энэхүү үзүүлэлтийг тооцохдоо Евро комиссын “European Business Cycle Indicators” тайланд тусгагдсан аргачлалын дагуу тооцлоо. Ажлын эрхлэлтийн хүлээлтийн индекс нь аж ахуйн нэгжийн түүвэр судалгаанд хамрагдсан таван үндсэн салбарын өгсөн хариултуудын жигнэсэн дунджаар тооцогдоно. Аж үйлдвэр (жин 40%), барилга (5%), хэрэглэгчид (20%), жижиглэн худалдаа буюу дотоод худалдаа (5%), үйлчилгээний салбарууд (30%) хамаарна. ААН-үүдээс **өнгөрсөн улирлын тодорхой бус байдлын** талаарх өөрчлөлтийг судалж, “Өссөн”, “Буурсан”, “Мэдэхгүй”, “Хэвэндээ” гэсэн дөрвөн хариултын эерэг/сөрөг балансаар тодорхойлсон болно.

Медиан утга (Symmetric Linear Interpolated Median)

Энэхүү үзүүлэлтийг тооцохдоо тоон асуулгын хариултаас Nicholas J. Cox (2009)-ийн боловсруулсан “Хагас тархалтын функц” болон “Симметрик шугаман интерполяци медиан” аргачлалыг ашиглан тоон хүлээлтийн тархалт болон медиан утгыг тооцсон болно. Хүлээлтийн утгыг тооцохдоо ХҮИ-д тулгуурлаж байгаа тул үнийн ерөнхий хандлагыг харуулна. Энэхүү тооцсон хүлээлтийн утга нь инфляцын утгыг шууд илэрхийлэхгүй болно